



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР  
ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2025 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 08

Хэрлэн сум

Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод-аудитын албаны санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч, дотоод аудиторын сул орон тоонд нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 5.7, 3.5, 3.5.4 дэх заалт, 2019 оны 14 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 7.2, 7.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн албаны тусгай шалгалтаар хамгийн өндөр оноо /62/ авсан Ганбатын Мөнхболдыг аймгийн Санхүүгийн хяналт, дотоод-аудитын албаны санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч, дотоод аудиторын сул орон тоонд томилуулахаар нэр дэвшүүлсүгэй.

2. Нэр дэвшигч Г.Мөнхболдыг тухайн албан тушаалд томилсон шийдвэрийг ажлын 14 өдрийн дотор албан бичгээр ирүүлэх шаардлагатайг аймгийн Санхүүгийн хяналт, дотоод-аудитын албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Д.Пүрэвжав/-д зөвлөсүгэй.

3. Энэхүү тогтоолыг аймгийн Санхүүгийн хяналт, дотоод-аудитын албанд хүргүүлж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ш.Эрдэнэжаргал/-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР